



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/45

Улаан-Уул

Үржлийн малд үзлэг ангилалт хийх,
цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтууд, аймгийн Засаг даргын 2022 оны А/235 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, ээмэглэж ялган тэмдэглэх, өсвөр хээлтүүлэгч шилэн сонгож өсгөн бойжуулах ажлыг 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны хооронд дараах бүрэлдэхүүнтэй зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: О.Энхболд (Хөдөө аж ахуйн тасгийн дарга, мал зүйч)

Гишүүдэд: Б.Азжаргал (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

О.Намжирмаа (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

Багуудын Засаг дарга нар

2. Үзлэг ангилалтад хамрагдах мал сүргийг тогтоосон хугацаанд бэлэн байлгах, хашаа хороогоор хангах, ээмэглэж бүртгэлд хамруулах малын судалгааг гарган малчдад зар мэдээллийг хүргэн ажиллахыг багуудын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээг календарчилсан төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн холбогдох байгууллагад хүргэж ажиллахыг ажлын хэсэг (О.Энхболд)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Г.Баттогтох)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

642201067